



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

“Эн Ви Си ББСБ” ХХК-ийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж аухйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эн Ви Си ББСБ” ХХК-ийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

2. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсонтой холбогдуулан холбогдох өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримтыг 2013 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Эн Ви Си ББСБ” ХХК /О.Бадрал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000063